хугацаанд бодлогын түвшинд 2%-д хүргэх зайлшгүй хэрэгтэй гэж үзэв. Иймд цэргийн төсвийн төлөвлөлтөд зорилгот-хөтөлбөрт суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлж, нөөцийг оновчтой хуваарилан, санхүүгийн ил тод байдлыг нэмэгдүүлэх нь үр ашигтай болохыг уг өгүүлэл онцолсон юм.

Түлхүүр үг: Төсөв, санхүүжилт, төсвийн ангилал, зорилтот хөтөлбөр, эдийн засгийн аюулгүй байдал.

I. УДИРТГАЛ

Дэлхий даяаршиж, үндэсний эрх ашиг, улс үндэстний бие даасан байдлыг эрхэмлэхээс гадна, улам бүр нийтлэг болж байгаа аюулгүй байдлын асуудалд хандах хандлага олон талтай болж, яриа хэлэлцээр, хамтын ажиллагааг дэмжих нь бүх нийтийн аюулгүй байдлыг хангахад чухал болоод байна. Харилцан хамаарал улам бүр өсөн нэмэгдэж буй эдүгээ үед аюулгүй байдал гэдэг нь харилцан уялдаатай үзэл баримтлал болж, зөвхөн идэвхитэй бүтээлч хамтын ажиллагаа л харилцан аюулгүй байдлыг баталгаажуулж байна. Улс хоорондын харилцаанд найрсаг итгэлцэлд тулгуурласан байдал улам бүр өргөжиж, эдийн засгийн хамтын ажиллагаа, хамаарал нь олон улсын харилцааны нэг чухал хүчин зүйл болж, тухайн улс орны аюулгүй байдалд хүчтэй нөлөөлөх болов. Олон улсын харилцааны төлөвт даяаршил, дэлхийд тэргүүлэх АНУ-ын байр суурь, Иракийн асуудал, Солонгосын хойг, улс үндэстэн дамжсан глобаль асуудлууд, бүс нутгийн хөгжлийн харьцаанд өөрчлөлт гарах төлөв, үндэстэн ястан хоорондын зөрчил, газар нутгийн маргаан, ардчилал ба энх тайван, тогвортой хөгжил гэсэн бодит нөхцөл байдал нөлөөлсөөр байна. Улс орнуудын харилцаанд цөмийн зэвсэг, зэвсэглэлээр хөөцөлдөхийг таслан зогсоох, зэвсэглэлд хяналт тавих, пуужингийн довтолгооноос хамгаалах систем байгуулах, орон нутгийн дайн, зэвсэгт мөргөлдөөн, үй олноор хөнөөх зэвсгийн тархалт, терроризмын аюул, олон улсын харилцаанд цэргийн хүч хэрэглэх явдал, цэрэг-улс төрийн эвсэл, улс орнуудын батлан хамгаалах төсвийн өсөлт зэрэг аюулгүй байдал, батлан хамгаалахын хамтын хүчин чармайлтаар шийдвэрлэх асуудлууд байсаар л байна⁴.

II. Үндсэн хэсэг

Тайван цагт бүхэлдээ цэргийн байгуулалт, зэвсэгт хүчний байгуулалтыг эдийн засгийн хувьд хангах гурван хувилбар байж болох юм гэж үздэг. Хэвийн нөхцөл : Эдийн засаг тогтвортой байж, тодорхой хурдацтай хөгжиж, улс орны дотоод болон дэлхийн бусад улс орнуудын практикт байгаа нийтээр хүлээн зөвшөөрөхүйц хязгаарлалтын хэм хэмжээний хүрээнд зэвсэгт хүчнээ тогтвортой санхүүжүүлэх байдал юм. Сүүлийн жилүүдэд ийм нөхцөл байдал АНУ, ОХУ, БНХАУ, Франц, Их Британи, Герман зэрэг улс оронд ажиглагдаж, тэдгээрийн ДНБ жил бүр 2.5%-5% -ийн тогтмол өсөлттэй байж, цэргийн зардал ДНБ-ний 2%-4%-ийг эзэлж байна.

⁴ Болдбаатар.З, “Батлан хамгаалахын бодлого, үйл ажиллагааны шинэ хандлага” 2016 он, илтгэл, хх8-9.

Тогтвортой хязгаарлалтын нөхцөл: Гүнзгий хямралын дараах эдийн засгийн өсөлтийн үе шатанд ажиглагддаг онцлог нөхцөл байдал бөгөөд ерөнхийдөө уг хязгаарлалтыг урьдчилан төсөөлж, цэргийн байгуулалтын зохих хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх боломжтой байдаг. Хатуу хязгаарлалтын нөхцөл: Цэргийн байгуулалтыг хөгжүүлэх төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлэх боломж хүндрэлтэй байдаг. Эдийн засаг тогтворгүй байх нөхцөлд батлан хамгаалах төсвийг бууруулах хандлага байдагтай уялдан батлан хамгаалах төсвийн доторх санхүүгийн хөрөнгийг анхдагч хувилбарын хувьд зориулалтаар нь дахин хуваарилах шаардлага гардаг байна. Батлан хамгаалах төсвийг зохиох, батлах, бүх үе шатанд цэргийн байгуулалтын зорилт, тэргүүлэх чиглэлүүдээр хязгаарлагдмал санхүүжилтийг хамгийн оновчтой хуваарилах хувилбарыг эрэлхийлэх хэрэгтэй болдог. Орчин үеийн нөхцөлд батлан хамгаалах төсвийг боловсруулах аргазүйн үндсийг дараах зарчмууд бүрдүүлж байна. Үүнд:

✓ *Тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зарчим:* Эдийн засгийн хатуу хязгаарлалтыг баримталж байгаа нөхцөлд цэргийн байгуулалтын тэргүүлэх чиглэлүүдийг заавал ялган тодорхойлох явдлыг агуулдаг.

✓ *Хувилбарын зарчим:* Санхүүжилтийн хязгаарлалттай нөхцөлд цэргийн байгуулалтыг хөгжүүлэх төсвийн захиалгын хувилбаруудыг боловсруулж, төр засгийн удирдлагад танилцуулах явдлыг агуулдаг. Батлан хамгаалах цогц арга хэмжээг цар хүрээ, төсвийн хувьд тогтоосон байхад зардлыг аль болох багасгах арга замыг эрэлхийлэхэд хувилбарын зарчим нэн ач холбогдолтой байдаг бөгөөд зэвсэглэл болон бие бүрэлдэхүүний тоо, чанар, санхүүгийн зардлын чиглэл, хүрээг тодотгон зохицуулах замаар энэ зорилтод хүрэх боломжтой.

✓ *Тэнцвэрт байдлын зарчим:* Байлдааны, удирдлагын, хангалтын гэсэн гурвалжин пирамид хүч хэрэгслийг зохицолт байдлаар хөгжүүлэх явдлыг өөртөө багтаадаг байна.


✓ *Зорилгот-хөтөлбөр –төлөвлөлтийн зарчим:* Улс орны хөрөнгө нөөц болон цэргийн байгуулалтын зорилго, зорилтуудыг нягт уялдаатай шийдвэрлэх боломж олгодог.

✓ *Зохицох зарчим:* Өмнөх жилүүдийн цэргийн бодит зардал, тэргүүлэх чиглэл, бий болсон ажлыг харгалзан үзэж шинэ санхүүжилтийг оновчтой хуваарилах явдал юм.

✓ *Шууд санхүүжүүлэх төлөвлөлтийн зарчим:* Зохион бүтээх үе шатанд байгаа зэвсэглэл, цэргийн техникийн “ оршин байх” мөчлөгийн нийт зардлыг шинжлэх явдлыг агуулдаг.

✓ *Нээлттэй байх зарчим:* Энэ зарчим улс орны доторх хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын болон олон нийтийн байгууллага зэрэг янз бүрийн бүтцүүд, түүнчлэн олон улсын байгууллагаас (НҮБ зэрэг) цэргийн зардлыг шинжлэх, хянах шаардлагаас урган гардаг. Энэ зарчим бий болсон шалтгаан нь улс орнуудын цэргийн бэлтгэл, зэвсэглэлээр хөөцөлдөхийг хязгаарлах, татвар төлөгчдөөс төвлөрүүлсэн үйлдвэрлэлийн бус зардал болох цэргийн зардлын талаарх олон нийтийн зүгээс анхаарал хандуулах болсонтой холбоотой юм.

Системийн хандлагын үндсэн дээр цэргийн санхүүжилтийн хэмжээг үнэлэх аргыг боловсронгуй болгох шаардлага өндөр байна. Иймд системийн хандлагаар төсвийн зүйлчилсэн ангиллыг боловсруулах буюу боловсронгуй болгох шийдлийн хувилбарыг дараах байдлаар схемчлэн тайлбарлая.



1.1.дүгээр зураг.Батлан хамгаалах төсвийн ангиллыг боловсруулах алгоритм⁵

⁵ Намсрай.Т, Нанжид.Д, “ Батлан хамгаалах төсөв боловсруулах аргазүйн асуудал ”2016 он, х55,

Сүүлийн жилүүдэд геостратеги, цэрэг-улс төр, нийгэм эдийн засаг болон хүн амзүйн нөхцөл байдалд гарсан үндсэн өөрчлөлт улс орон бүрийн ҮЭЗАБ-ыг хангах, эдийн засгийн боломж, зэвсэгт хүчний үүрэг, байр суурь, төрөл цэргийн бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтийн зорилгыг үндэслэх, түүнчлэн зэвсэгт хүчнийг хөгжүүлэх болон дайчилгааны бэлэн байдлыг зохих түвшинд байлгахтай холбоотой төсвийн зардлыг үнэлэхэд шинэ байдлаар хандах шаардлагатай болжээ.

Цэргийн шинэчлэл нь улс орны цогц өөрчлөлт шинэчлэлтийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд эдийн засаг, улс төр, нийгэм, эрхзүй, цэргийн зэрэг өөрчлөлтийг багтаасан нийгмийн түвэгтэй үзэгдэл юм. Иймд дотоодын тогтвортой байдлыг хангах нь “нийгмийн хамгаалалтын” болон “эдийн засгийн хамгаалалтын” үүрэг болдог. Эдийн засгийн болон нийгмийн хамгааллын бүрдэл хэсэг нь хоорондоо нягт уялдаа холбоотой бөгөөд манай нийгмийн хөгжлийн онолын үндэслэл одоогоор хараахан бүрэн боловсрогдохгүй байгаа боловч ийм цогц хөгжлийн онолын бодлогын үндэслэлийг бий болгосон үед л ЭЗАБ-ын тодорхой, урт хугацаанд мөрдөгдөх үзэл баримтлалыг боловсруулах бололцоотой юм гэж судлаачид, эдийн засагчид үздэг.

Төсвийн зардлыг ангилах нь чиг үүргээр зардлыг хуваарилах шийдвэрийн үндэслэлийг сайжруулах, зориулалтын дагуу зарцуулж байгаад хяналт тавих, түүнчлэн цэргийн зардлын хэмжээ, бүтцийн хувьд харьцуулан шинжлэх боломж олгож, төсвийн санхүүжилтийн ерөнхий тогтолцоонд ихээхэн үүрэгтэй байдаг бөгөөд цэргийн зардлын ангиллын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, практик хэрэгцээнд нийцүүлэх боломж олгодог.


Дэлхийн улсуудын батлан хамгаалахад гарч буй өөрчлөлтүүд, шинэ чиг хандлагууд нь иргэний ардчилсан, хүмүүнлэг нийгэмд батлан хамгаалах салбарын гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийг шинээр тодотгон тогтоож байна.

III. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Цэргийн байгуулалтыг хөгжүүлэх асуудлыг зорилго, зорилтууд, хугацаа, гүйцэтгэгч, нөөц, хуваарилсан санхүүгийн хөрөнгөөр бүхэлд нь нягт уялдуулсан цогц тогтолцоог бүрдүүлэх нь төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх, төсөвлөсөн санхүүгийн хөрөнгийг үр өгөөжтэй ашиглахад нөлөө үзүүлдэг. Төсөвлөсөн санхүүгийн хөрөнгийг үр өгөөжтэй ашиглахад ОХУ-ын “зорилгот-хөтөлбөр-төлөвлөлт”-ийн аргыг хэрэглэх нь илүү үр дүнтэй гэж ойлгогдохоор байгаа юм. Учир нь энэхүү хөтөлбөр нь улс орны “хүчний” бүтцүүдийн хэрэгцээг цогц байдлаар тодорхойлох, бүтэц, бүрэлдэхүүний тоог оновчтой болгох, илүү шат дамжлага, ажил үүргийн давхардал, үрэлгэн байдал зэрэг үйл ажиллагааны сөрөг үр дагаварыг арилгах урьдчилсан нөхцөл бүрдүүлдэг. Энэхүү хөтөлбөрийн давуу тал нь цэрэгт үзүүлэх дэмжлэг, батлан хамгаалах чадавхийг зохих түвшинд бий болгож чаддаг байна. Батлан хамгаалах төсөв зохиох үйл явцыг боловсронгуй болгох зорилгоор нэгд, цэргийн төсвийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх олон

талт түвэгтэй шинжийг агуулсан “зардал”, “санхүүжилт”, “үүрэг зорилт”, гэсэн харилцан уялдаатай санхүүгийн үзүүлэлтийн тогтолцоог хэрэглэхэд шилжих, хоёрт, цэргийн төсвийн зориулалтыг хуульчлан сахих, гуравт, тайлан, бүртгэл тооцоо, зэвсэг, техникийн захиалга, цэргийн бүтээгдэхүүний үнэ бүрдэл зэрэг асуудлыг боловсронгуй болгох, дөрөвт, зах зээлийн нөхцөлд цэрэг-эдийн засгийн үйл ажиллагааг удирдах шинэ механизмыг бий болгох, тавд, иргэний засаглал, нийгмийн зүгээс цэргийн төсвийн зарцуулалтад байнга хяналт тавих шаардлага зүй ёсоор тавигддаг нь ойлгомжтой.

*Төсвийн төлөвлөлтийн зорилгот хөтөлбөрийн хандлагыг дараах бүдүүвчээр тайлбарлая*⁶



1.2. дугаар зураг. Төсвийн төлөвлөлтийн зорилгот хөтөлбөрийн хандлагын бүдүүвч.

Төсвийн төлөвлөлтийн зорилгот хөтөлбөрийн хандлага нь нэгд, зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хэтийн төлөвийг тодорхойлох, хоёрт, тавигдсан зорилгод хүрэх арга хэмжээг цогц байдлаар авч үзсэн дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулах, гуравт, батлан хамгаалах төсвийг боловсруулах гэсэн хоорондоо нягт уялдаатай дараалсан гурван үе шатыг багтаах болж байна.

Санхүүжилтийн эх үүсвэр, хэмжээг шийдвэрлэхтэй хамт зорилгот хөтөлбөрийн төлөвлөлтийг боловсруулдаг байна. Улс орны санхүү – эдийн засгийн боломж хязгаарлагдмал нөхцөлд зорилгот- хөтөлбөр бүрт нэгд, цэргийн үйл ажиллагааны урсгал зардал, хоёрт, байлдааны бэлтгэлийн хангалтхүч хэрэгслийг хэрэглэх, гуравт, зэвсэглэл, цэргийн техник, цэргийн дэд бүтцийг хөгжүүлэх гэсэн санхүүжилтийн түвшингээр гүйцэтгэж байгаа байдалтай байна. Тухайн хөтөлбөрт тодорхойлсон зорилго, тэргүүлэх чиглэлийн дагуу санхүүжүүлэхийг чухалчилдаг.

Цэргийн байгуулалтыг хөгжүүлэх төлөвлөлтөд зорилгот- хөтөлбөр-төлөвлөлтийн аргыг хэрэглэснээр олон давуу боломжийг олгодог. Үүнд:

1. Зэвсэгт хүчний байгуулалтын уламжлалт төлөвлөлт болон жил бүрийн батлан хамгаалах төсвийн боловсруулалт хоорондын нягт уялдаагүй байдал арилж, батлан хамгаалах төсвийн төлөвлөлт, хөтөлбөржүүлэлт болон боловсруулалтын явц нэгдмэл тогтолцоотой болох;

⁶ Намсрай.Т, Нанжид.Д, “ Батлан хамгаалах төсөв боловсруулах аргазүйн асуудал ”2016 он, х121, ISBN 978-99973-992-6-7.

2. Улс орны санхүүгийн болон эдийн засгийн боломжийг харгалзан тооцсон нөөцийн хүрэлцээтэй, бодитоор биелэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

3. Зэвсэгт хүчний урсгал болон хэтийн хэрэгцээг үнэн зөв үндэслэлтэй тодорхойлж, хөтөлбөр бүрийн хүрээнд өртөг зардлыг үнэлэх, бүхэлд нь өртөг зардлыг хүлээгдэж буй үр дүнтэй нь харьцуулан жиших;

4. Цэргийн тавигдсан зорилгод хүрэх олон хувилбарыг боловсруулан харьцуулан жишиж, батлан хамгаалахын төсвийн хязгаарлагдмал санхүүжилтийг хуваарилах асуудлыг хөтөлбөр тус бүрээр оновчтой шийдвэрлэх боломжтой хувилбарыг сонгох;

5. Батлан хамгаалахын төсвийг цэргийн хөтөлбөрүүдтэй, хөтөлбөрүүдийг батлан хамгаалахын төлөвлөлт болон зэвсэгт хүчний бүтэц, бүрэлдэхүүний хэмжээ, түүнийг цэргийн номлолтой, цэргийн номлолыг улсын үндэсний сонирхол, улс төрийн зорилго, төлөвлөгөөтэй уялдуулах;

6. Жил бүрийн батлан хамгаалах төсвийн хэмжээ, бүтцийн үндэслэлийг бодитоор гаргах зэрэг юм.

Ийнхүү зорилгот –хөтөлбөр төлөвлөлтийн хандлагын үед зөвхөн дараах оны төсвөөр хязгаарлахгүй, боловсруулсан урт хугацааны хөтөлбөрт тулгуурлан цэргийн болон зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн хэтийн төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэслэлтэй зохиох боломж олгодог байна. Батлан хамгаалах төсвийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоход батлан хамгаалах зардлыг үнэлэхэд шинэ хандлагаар хандах хэрэгцээ шаардлага урган гарсан. Тухайлбал, цэрэг-эдийн засгийн шинжилгээний үр дүнд тулгуурлан гаргаж буй шийдвэрийн үндэслэлийг олон хувилбараар авч үзэх, санал болгож буй хувилбаруудыг “үр дүн–өртөг- хэрэгжилт” шалгуураар үнэлж материалын болон санхүүгийн нөөцийг цэргийн ажиллагааны чадавхийг хамгийн өндөр түвшинд дээшлүүлэх чиглэлд төвлөрүүлэх, хөрөнгө оруулалтын бодит хязгаарыг тогтоох, цэргийн техникийн ажиллагааны нөөц болон сайжруулалтын боломжийг дээд зэргээр ашиглах, үнэ бүрдэлтийн системийг боловсронгуй болгох, материалын болон санхүүгийн нөөцийн зарцуулалтыг ил тод болгох зэрэг болно.

Улс орны цэргийн байгуулалтын төсвийн болон төсвийн гадуурх санхүүжилтийг оновчтой хослуулах зарчим баримтлахыг санал болгож байна.

Цэргийн зардлын урт хугацааны санхүүжилтын төлөв байдлыг бусад улс орнуудынхтай харьцуулахад дараах байдалтай байгаа юм. Дунджаас доогуур орнуудынхаас манай улсын цэргийн зарцуулалт доогуур байгаа нь судалгаанаас харагдаж байна. Иймд дэлхийн батлан хамгаалах бодлого, хөгжлийн хандлага тэлж байгаа өнөө үед ядаж өөрийгөө хамгаалах чадавхитай байхын тулд цэргийн зарцуулалтын эрэлт нэмэгдэх шаардлагатай болж байгаа билээ. Тиймээс дунд хугацаанд биш юмаа гэхэд урт хугацаанд батлан хамгаалах бодлогын баримт бичигт тусгасан 2%-ийн хэмжээнд цэргийн зардлыг нэмэгдүүлэх бодлого баримтлах биш хэрэгжүүлэх хэрэгтэй.

Дэлхийн олонх улс оронд зэвсэгт хүчний шинэчлэл санхүүгийн хатуу хязгаарлалтын нөхцөлд явагдаж байна. Улс орон бүр дотоодын нөөц бололцоогоо

шаргуу эрэлхийлж байгаа өнөө үед цэрэг-эдийн засгийн шинжилгээ хийх, түүн дотор тоон шинжилгээ хийх аргыг хэрэглэх шаардлага тавигдаж байна.

Батлан хамгаалах эдийн засаг дахь ялгаатай бүтээмж ба уг секторын гадаад үр нөлөөг "Feder-Ram"-ын загвараар илэрхийлсэн тэгшитгэлээр дараах байдлаар авч үзье.

$$\dot{Y} = \beta_1 \cdot \frac{I}{Y} + \beta_2 \dot{L} + \beta_3 \dot{M}^M + \beta_3 \dot{M} + \mu, \quad (1.1.)$$

$$y = \alpha_0 + \alpha_1 \ln l + \alpha_2 \ln K + \alpha_3 \ln M + \mu, \quad \alpha_1, \alpha_2, \alpha_3 > 0 \quad (1.2.)$$

Feder-ийн загварт тулгуурлан Ando 2009 онд батлан хамгаалах болон эдийн засгийн өсөлтийн хамаарлыг судлав. Тэрээр 109 орны 1995-2003 оны эмпирик судалгаанд үндэслэн хоёр сектор байна гэж үзэн олон хүчин зүйлийн шугаман регрессийн тэгшитгэлийг дараах байдлаар үнэлжээ.

$$GDP \int (EX, IMP, INV, ME)$$

GDP – ДНБ

EX – Нийт экспорт;

IMP – нийт импорт;

INV – дотоодын нийт хөрөнгө оруулалт;

ME – цэргийн зардал.


Нийгмийн бодлого эдийн засгийн өсөлтийн хооронд хүчтэй харилцаа байгаа нь макро эдийн засгийн болон санхүүгийн үзүүлэлтүүдийн хувьсагчдаар нотлогдов. Энд засгийн өсөлт батлан хамгаалах зардалд нөлөөлнө, батлан хамгаалах зардал эдийн засагт нөлөөгүй гэсэн дүгнэлтэнд хүрчээ.

Тэгвэл манай улсын хувьд ямар байхыг энгийн шугаман регрессээр тооцоолоход урт хугацаанд (1997-2024 он) эдийн засгийн өсөлт ба цэргийн зардал хоорондоо хамааралгүй байлаа. Өөрөөр хэлбэл харилцан бие биедээ нөлөөгүй гэсэн үг. Үүнийг дараах тооцооллын үр дүн гэрчилнэ.

1.1. дүгээр хүснэгт.

Dependent Variable: RGDPG / g /				
Method: Least Squares				
Date: 08/11/25 Time: 21:17				
Sample: 1 28	g c m			
Included observations: 28				
Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	7.190705	1.816169	3.959271	0.0006
M	-1.631507	0.772081	-2.113129	0.0447
R-squared	0.151545	Mean dependent var		4.181481
Adjusted R-squared	0.117607	S.D. dependent var		6.235077
S.E. of regression	5.856969	Akaike info criterion		6.444329
Sum squared resid	857.6022	Schwarz criterion		6.540317
Log likelihood	-84.99844	Hannan-Quinn criter.		6.472871
F-statistic	4.465315	Durbin-Watson stat		0.894375
Prob(F-statistic)	0.044745			

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол.



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол.

1.3. дугаар зураг. Тэгшитгэлийн үр дүнгийн зураглал.

Мөн ХБКА (хамгийн бага квадратын арга)-аар 1997-2024 оноор төсвийн зарлагад цэргийн зардлын эзлэх хувь (GM), ДНБ-д цэргийн зардлын эзлэх хувь (M) зэргийг нэг хувь өсгөхөд ДНБ-ний бодит өсөлт (G буюу RGDPG) 2,14% ба -0,49%-иар тус тус буурч байна. Энд үлдэгдлийн графикаас нь үзэхэд алдааны илэрхийлэл нь гомоскедастик буюу тэнцүү дисперстэй байна гэж хэлэх боломж бага зэрэг байна. Хэдийгээр алдааны илэрхийллийн хэлбэлзэл нэмэгдэж байгаа нь цаг хугацааны явцад хааяа нэг илэрч байгаа ч дийлэнхидээ гетероскедастикийн асуудалгүй гэж үзлээ. Иймд шугаман регрессийн сонгодог нөхцөл болох дисперсүүд нь тэнцүү байна гэсэн нөхцөл зөрчигдөхгүй болно. Гэвч “Unit Root” тестээр шалгахад батлан хамгаалах зардлын эдийн засгийн өсөлтөнд үзүүлэх сөрөг нөлөөллийн хүч саарч байна. Энэ нь мөн энэ хоёрын хооронд хамаарал сулхан байдгийг нотлон харуулж буй хэрэг юм.

“VAR” загвараар үнэлсэн ЭЗАБ (Эдийн засгийн аюулгүй байдал)-ын эерэг тал болох эдийн засгийн өсөлтөнд нөлөөлж буй төсөв- санхүүгийн үзүүлэлтүүдийн нөлөөлөл хоёр дахь жилээс хойш нөлөөлөл суларч байснаар мөн тайлбарлагдана.

“Arch” загвар нь санхүүгийн хувьсагчдын цаг хугацааны явцад онцлог ялгаа бүхий эерэг, сөрөг шокод үзүүлэх харилцан адилгүй нөлөөг харуулна. Шугаман регрессийн тэгшитгэлтэй харьцуулахад стандарт алдаа нь багасч, ач холбогдолтой гардгаараа давуу талтай билээ.

“Arch” загвараар дээрх шугаман регрессийн тэгшитгэлийг үнэлэхэд төсвийн зарлагад цэргийн зардлын эзлэх хувь (GM), ДНБ-д цэргийн зардлын эзлэх

хувь(М) зэргийг нэг хувь өсгөхөд ДНБ-ний бодит өсөлт (G буюу RGDPG)1,06% ба -1,86%-иар тус тус буурч байна. Гэвч критик утгаас шалгуурын статистик утга давж гарахгүй, 5%-ийн магадлалын утга нь ач холбогдлын түвшингийн утгаас бага гарсан тул эдийн засгийн өсөлтөнд батлан хамгаалах зардал тийм ч их нөлөөтэй биш байна. Өөрөөр хэлбэл энэ нь бидний өмнөх тооцсон ДНБ-ний бодит өсөлт ба цэргийн зардал хоорондоо хамааралгүй гэсэн үнэлгээг давхар баталж байгаа талтай. Дараах хүснэгтээр үнэлгээний үр дүнг харууллаа.

1.2. дугаар хүснэгт.

Dependent Variable:RGDPG / G /				
Method: ML - ARCH (Marquardt) - Normal distribution				
Date: 08/11/25 Time: 02:09				
Sample: 1997 2024				
Included observations: 28				
Convergence achieved after 72 iterations				
Presample variance: backcast (parameter = 0.7)				
GARCH = C(4) + C(5)*RESID(-1)^2 + C(6)*GARCH(-1)				
Variable	Coefficient	Std. Error	z-Statistic	Prob.
C	11.51166	2.128043	5.409507	0
GM	-1.063707	1.094133	-0.972192	0.331
M	-1.8634	2.689647	-0.692804	0.4884
	Variance Equation			
C	0.894422	2.697669	0.331554	0.7402
RESID(-1)^2	1.218807	0.676922	1.800514	0.0718
GARCH(-1)	0.259516	0.212484	1.221344	0.222
R-squared	0.403028	Mean dependent var		4.155556
Adjusted R-squared	0.353281	S.D. dependent var		6.128203
S.E. of regression	4.928231	Akaike info criterion		6.235995
Sum squared resid	582.8989	Schwarz criterion		6.523959
Log likelihood	-78.18593	Hannan-Quinn criter.		6.321622
Durbin-Watson stat	1.096863			

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол.

Дунд хугацаанд (2020-2024 он) нийгэм эдийн засгийн нөхцөл байдал сайжрахгүй тохиолдолд ДНБ-д цэргийн зардлын эзлэх хувь хэмжээний доод хязгаар нь 0,73%-1,25%, дээд хязгаар нь 0,85%-1,53% байх шаардлагатай гэсэн тооцоолол гарлаа.

Үйл ажиллагаанд цэрэг-эдийн засгийн шинжилгээ хийсний үр дүнд нэгд, зэвсэгт хүчний бүтэц орон тооны зохион байгуулалтын үндэслэл, арга хэмжээний төлөвлөгөөний оновчтой байдал, тухай бүр нөөцөөр хангах байдал зэрэг үйл ажиллагааны зохион байгуулалтын түвшин, хоёрт, бие бүрэлдэхүүн, зэвсэглэл, техник, материал хэрэгсэл, мөнгөн хөрөнгө зэрэг нөөцийн хэмжээ, гуравт, зэвсэглэл, цэргийн техникийн тактик-техникийн үзүүлэлт, цэргийн мэргэжилтнүүдийн тусгай бэлтгэлийн түвшин зэрэг нөөцийн хэмжээ, чанар, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны аргыг өөрчлөх замаар нөөцийг ашиглах янз бүрийн өгөөжит байдалд хүрч болох юм.

Батлан хамгаалах салбарын төсвийн санхүүжилтын хэм хэмжээ ЭЗАБ-д чухал нөлөөтэй байдаг. Учир нь батлан хамгаалах салбар нь аюулгүй байдлыг хангахад тэргүүлэх ач холбогдолтой салбар юм. Дэлхийн цэргийн хүчний зарцуулалт нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд Монгол Улсын батлан хамгаалах салбарын төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага байна. Тухайлбал, ДНБ-д цэргийн зардлын эзлэх хувь хэмжээг 2%-3%-д, төсвийн зарлагад батлан хамгаалах зардлын эзлэх хувь хэмжээг 3%-5%-д тус тус хүргэх нь чухал болоод байгааг судалгааны ажлаараа харуулав.

IV. ДҮГНЭЛТ

Батлан хамгаалах төсвийн санхүүжилтийн оновчтой зохион байгуулалт нь зөвхөн эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтэд тулгуурлах бус, харин үндэсний аюулгүй байдлын баталгааг хангах урт хугацааны стратегийн бодлоготой нягт уялдан хэрэгжих шаардлагатай болохыг судалгааны үр дүн нотоллоо. Шинжилгээнд суурилсан тооцооллоор цэргийн зардал ба эдийн засгийн өсөлт хоорондын хамаарал статистикийн хувьд сул илэрсэн ч батлан хамгаалах салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх нь аюулгүй байдлын чадавхыг бэхжүүлэх зориулалтын хөрөнгө оруулалт бөгөөд эдийн засгийн тогтвортой байдлын баталгаа гэдгийг харууллаа.

Төсвийн хүрэлцээ хязгаартай нөхцөлд батлан хамгаалах зардлын бүтцийг оновчтой хуваарилах арга зам бол зорилтот-хөтөлбөрт суурилсан төлөвлөлт, хөрөнгө оруулалтын олон хувилбарын үнэлгээ, үр дүн-өртгийн шалгуурт тулгуурласан шийдвэр гаргалт чухал болохыг онцлов. Судалгаанд боловсруулсан төсвийн ангиллын алгоритм нь зардлын бүтцийг ил тод, үр ашигтай болгох боломжтой бөгөөд дунд хугацаанд батлан хамгаалах төсвийн хэмжээг ДНБ-ний 0.73%-1.53%-ийн хүрээнд, урт хугацаанд 2%-д хүргэх шаардлагатай гэсэн бодлогын зөвлөмж гарлаа. Иймд батлан хамгаалах төсвийн санхүүжилтийн шинэчлэл нь системийн шинжилгээнд тулгуурласан төлөвлөлт, санхүүгийн хариуцлагатай удирдлага, ил тод хяналтын механизмтай уялдах нь цэргийн болон

зэвсэгт хүчний байгуулалтын хөгжлийг дэмжиж, эдийн засгийн аюулгүй байдлын тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэх юм.

ЭШ ТАТСАН СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

- [1] З.Болдбаатар. “Батлан хамгаалахын бодлого, үйл ажиллагааны шинэ хандлага” 2016 он, илтгэл, хх8-9.
- [2] Т.Намсрай, Д.Нанжид., “Батлан хамгаалах төсөв боловсруулах аргазүйн асуудал” 2016он, х121, ISBN 978-99973-992-6-7.
- [3] Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал, 2014 он УБ, х.22 ISBN 978-99973-43 -50-5.
- [4] В.И.Карпов. Основы теории обеспечения безопасности личности, общества и государства. Учебное пособие, Москва, 2000 год, х.26.
- [5] Бор.Ж, Чулуунбат.В, “Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс”, УБ 2012 он, х.116. ISBN.978-99962-1-587-2.
- [6] Абалкин.Л “Экономическая безопасность России”: угрозы и их отражение, х47.
- [7] Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010 он.
- [8] Тунгалаг.Д, “Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын онол практикийн зарим асуудал” 2015 он. Х46-48, ISBN 978-99973-956-1-0.
- [9] Финасово-экономическая безопасность в условиях открытости национальной экономики
- [10] МУИС-ЭЗС. (2009). “Монгол улсын эрх чөлөөний эдийн засгийн тойм 2008”: Эдийн засаг дахь төрийн оролцоо. УБ., Sodpress ХХК, х17.
- [11] Robert. L. Mc.Can. (1992). An outline of the American economy. х107.
- [12] Батлан хамгаалах яам. (2021). *Батлан хамгаалах яамны стратегийн төлөвлөгөө /2021-2024/*. Улаанбаатар.
- [13] Монгол Улсын Сангийн яам. Сандагдорж, Э., Доржханд, С., Эрдэмчимэг, С., Энхбат,А., Батсүх,Т. (2008). *Улсын төсвийн байгууллагын хэтийн төлөвлөлт, бүтээгдэхүүн болон хөтөлбөрт суурилсан төсөвлөлт*. гарын авлага. Улаанбаатар.
- [14] Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль (2015);
- [15] Төсвийн тухай хууль (2011);
- [16] Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (ТХМ);
- [17] УИХ (2020). 52 дугаар тогтоол. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- [18] Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2016-2020, 2020-2024);
- [19] Сангийн яамны Сангийн сайдын 7 дугаар тушаал (2015) Хөтөлбөрийн ангиллын тухай;
- [20] УИХ-ын 2015 оны 85-р тогтоол Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс;
- [21] Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030.